Бөөрний багц шинжилгээний бэлтгэл

Шээсний шинжилгээг 2 саванд авна уу.

Шээсний шинжилгээний бэлтгэл:

• Гадна бэлэг эрхтэнг угааж арчисны дараа ариутгасан зориулалтын савны тагийг зөвхөн шээх үедээ онгойлгож шээсний дунд хэсгээс өгнө.
• Шөнийн турш давсганд хуримтлагдсан өглөөний шээснээс зориулалтын ариун саванд авч 2 цагийн дотор лабораторит хүргэсэн байна.
• Хэрвээ 2 цагаас илүү хугацаагаар хадгалсан бол устгаж, эхний шээснээс хойш 2 цаг орчим давсганд хуримтлагдсан шээсний дунд хэсгээс дахин зориулалтын саванд авч өгнө.
Шээсний ерөнхий шинжилгээний сорьцыг хөлдөөж болохгүй.

Шээсний ариун чанарын шинжилгээний бэлтгэл:

• Ямар нэгэн антибиотик уугаагүй, сарын тэмдэг ирээгүй байвал зохино.
• Шээс үедээ савны тагийг онгойлгож биедээ хүргэхгүйгээр шээх үеийн дунд хэсгээс савны дунд хүртэлх хэмжээний шээсийг тосч аваад шууд таглана. Нян судлалын лабораторид өгнө.
• Шинжилгээний хариу 72 цагийн дараа гарахыг анхаарна уу

Цусны шинжилгээний бэлтгэл:

• Өлөн байх /8–12 цагийн турш хоол идээгүй болон газтай болон чихэрлэг ундаа, зөгийн бал болон чихэртэй цай уугаагүй байх/
• 24 цагийн өмнөөс архи согтууруулах ундаа хэрэглээгүй, өөх тос ихтэй хоол идээгүй байх , биеийн хүчний дасгал болон хэт ачаалал аваагүй байвал илүү тохиромжтой.
• Цус өгөхийн өмнө эхо, дуран, рентген зэрэг шинжилгээнд багажийн шинжилгээнд ороогүй, судсаар тодосгогч бодис хэрэглээгүй байна.

Компьютер томографийн шинжилгээ:

Компьютер томографийн шинжилгээ нь цээжний болон хэвлийн хөндийн цуллаг эрхтнүүдийн голомтот өөрчлөлтүүдийг оношлох өндөр ач холбогдолтой бөгөөд оношлогооны чадвар болон ялган оношлогоог нэмэгдүүлэх зорилгоор тодосгогч бодис хэрэглэдэг. Уг бодисыг шинжилгээний явцад автомат тариурын тусламжтай судсаар тарина. Цөөн тохиолдолд тодосгогч бодист харшлах, дотор муухай оргих, бөөлжих зэрэг гаж нөлөө илэрч болох тул шинжилгээний өмнө зөвшөөрлийн хуудас бөглүүлж, харшлын сорил хийнэ. Хэрвээ тухайн бодист харшилвал тодосгогч бодисгүй орох шаардлага гарч болно. Багцад орсон бүх шинжилгээний нийт үнийн дүнгээс тодорхой (20%) хувиар хямдруулсан байдаг тул тодосгогч бодис харшилсан тохиолдолд буцаан олголт хийх боломжгүйг анхаарна уу! (Дэлгэрэнгүй зааврыг шинжилгээнд орохын өмнө мэргэжлийн сувилагч танилцуулж, сорилыг хийх болно.)

Жич: Дээрх шинжилгээний хариу гарсны дараа нэмэлт шинжилгээ шаардлагатай бол төлбөр тусдаа тооцогдоно.
Бусад нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх шаардлага гарвал 7 хоног дотор үзлэгийн төлбөрөөс 50%–ийн хөнгөлөлт эдлүүлнэ.